



“ЦАГААННУУР” ЧӨЛӨӨТ БҮСИЙН
ЗАХИРАГЧ А.АМАНКЕЛДИ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.20 № 3/272
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Цагааннуур” чөлөөт бүсийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Цагааннуур” чөлөөт бүсийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА



**ЦАГААН НУУР ХУДАЛДААНЫ ЧӨЛӨӨТ БҮС
ТӨСВИЙН 2016 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

YAG-ын САГ-ын дарга Тэргүүлэх
аудитор
Ц.Наранчимэг
Утас:261663
Цахимхаяг:

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512
Цахимхаяг:

Аудитор: Б.Сэржмядаг
Утас: 260512
Цахимхаяг:
serjmyadagb@audit.gov.mn

Гүйцэтгэх захирал: С.Оюунгэрэл
Утас: 99170900, 88007172
И-мэйл: oyungerel@cra.mn
Аудитор: П.Нарантуяа
Утас: 88002718
Менежер: Ц.Сайнзаяа
Утас: 99087446
Голден пэйж Аудит ХХК
Сүхбаатар дүүрэг 6-р хороо
Метро бизнес төвийн 8 давхар
Утас :70117179
Факс: 976-70117179

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Материаллаг байдал
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.5 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Цагааннуур” чөлөөт бүсийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Цагааннуур” чөлөөт бүсийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Цагааннуур” чөлөөт бүсийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 20-ны хооронд хийхээр төлөвлөн Голден пэйж Аудит ХХК-ийн аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Цагааннуур” чөлөөт бүсийн 2016 оны санхүүгийн тайланг 2016 оны 1 дүгээр сарын 13-нд Голден пэйж Аудит ХХК-д ирүүлсэн байна.

Голден пэйж Аудит ХХК-нь аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 14-нөөс 2017 оны 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 21-нд “Цагааннуур” чөлөөт бүсийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Цагааннуур” чөлөөт бүсийн төсвийн захирагч нь Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Төсвийн тухай хууль” “Чөлөөт бүсийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдөр тус тус УИХ-аар батлагдан 2016 оны 1 дүгээр сарын 1-ээс шинэчилсэн найруулгаар хэрэгжиж эхлээд байна. Эдгээр хууль тогтоомжуудтай холбоотой журам, зааварт өөрчлөлт оржээ.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Цагааннуур” чөлөөт бүс нь “Олон улсын түвшинд хүрсэн жишиг чөлөөт бүсийг байгуулж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын өсөлтийг тэргүүлэгч, эрчимтэй хөгжлийн төв болгон, баруун бүс нутгийн хөгжлийг хурдасгах замаар Монгол Улсын нийгэм, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд оршино.” гэж байгууллагын зорилгыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу “Цагааннуур” чөлөөт бүсийн дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

“Цагааннуур” чөлөөт бүсийн 2016 оны төсвийг сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Цагааннуур” чөлөөт бүсийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Цагааннуур” чөлөөт бүсийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 16 хийж гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад:

“Цагааннуур” чөлөөт бүс нь өөрийн байгууллагад мөрдөгддөг нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тайлант онд шинэчлэн боловсруулж, мөрдөн ажиллаагүй, өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

“Цагааннуур” чөлөөт бүсийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерын системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Цагааннуур” чөлөөт бүсийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн Виница програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Цагааннуур” чөлөөт бүсийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хангалтгүй байна.

Материаллаг байдлын түвшин:

“Цагааннуур” чөлөөт бүсийн материаллаг байдлын түвшинг тодорхойлохдоо 2016 оны нийт хөрөнгө 969.3 сая төгрөгөөс материаллаг байдлын суурь болгон түүний 1 хувиар тооцож 9.7 сая төгрөг гэж тогтоов.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийн зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

“Цагааннуур” чөлөөт бүсийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс урсгал зардалд 279.1 сая төгрөгийн санхүүжилт авсан ба төрийн өмчийг түрээслүүлснээс 7.1 сая төгрөг, чөлөөт бүсийн эзэмшлийн газраас 56.1 сая төгрөгийн орлого тус тус олжээ.

Нийт үйл ажиллагааны зардалд 392.7 сая төгрөгийг зарцуулж, 50.3 сая төгрөгийн үйл ажиллагааны үр дүнтэй ажиллажээ.

Шилэн дансны мэдээлэл

“Цагааннуур” чөлөөт бүс нь төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан талаар тодорхой мэдээлэл өгөхийн тулд “Шилэн дансны тухай” хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Шилэн дансны тухай хууль 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан тус байгууллага нь өөрийн байгууллагын www.tsagaannuur.freezone.gov.mn вэбсайт-нд байгууллагын танилцуулга, санхүүгийн удирдлага, холбогдох ажилтнуудын мэдээлэл, төсвийн гүйцэтгэл зэргийг байршуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 16 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 30 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж харвал:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ шинэчлэн сайжруулах талаар өмнөх жилд өгч байсан зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй
- Дотоод хяналт үр нөлөөгүй
- Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэдэг
- Үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулах арга, ашиглалтын хугацааг өөрийн байгууллагын онцлогт тохируулан шинээр тогтоож, мөрдөн ажиллаагүй, өмнөх жилийн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй
- Нягтлан бодох бүртгэлд аккрузл суурийг мөрдлөг болгоогүй
- Нягтлан бодогч ажлын байрны тодорхойлолтонд заасан ажил үүргийг үнэн зөв чанартай сайн хийж гүйцэтгээгүй
- Цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан албан татварын тайлангаа үнэн зөв тайлагнадаггүй
- Бараа материалын үлдэгдэлд тооллого хийж тооцоо бодоогүй
- Тайлант оны бүх ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, УСНББОУС, санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, үнэлгээ, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлүүдтэй тус тус нийцэхгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

“Цагааннуур” чөлөөт бүсийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бараа материал, дансны авлага, үндсэн хөрөнгө, дансны өглөг, түрээсийн орлого, бусад орлого, цалин хөлс, нийгмийн даатгал, шуудан холбоо, төлбөр хураамж зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг

шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн сайжруулах талаар зөвлөмж өгснийг тайлант онд хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-г "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Чөлөөт бүсийн захирагчийн 2017 оны 02 дугаар сарын 10-ны 11 тоот албан бичгээр тайлант онд боловсруулан мөрдөж ажиллахаа мэдэгдэв.

2. Тайлант онд дотоод хяналтын ажилтан /мэргэжлийн бус/ байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан гэх боловч, байгууллагад бүртгэлээр тавих хяналт сул, мэргэжлийн ур чадвар дутмаг, ажлын үр дүн чанар муутай, нягтлан бодогчийн хийж гүйцэтгэсэн ажилд хяналт хангалтгүй тавьдаг

Тайлант онд харилцагч байгууллагуудтай байгуулсан гэрээнүүдэд жагсаалт /товъёог/ үйлдэн хэрэгжсэн, хэрэгжээгүй гэрээнүүдийг дүгнэдэггүй

Нягтлан бодогч нь /Бизнес менежмент мэргэжилтэй/ ажлын байрны тодорхойлолтонд заасан ажил үүргийг үнэн зөв чанартай сайн хийж гүйцэтгээгүй, нягтлан бодогчийн ажлын байрны тодорхойлолтонд хүчингүй болсон хууль тогтоомжийг ашигласан ба мэргэжлийн мэдлэг дутмаг байгаа нь:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно”,
- Төсвийн тухай хуулийн 16.5.6-д "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх"
- Сангийн сайдын 2012 оны 294 тоот төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журмын 2.1.5-д Шууд захирагч нарын ахлах нягтлан бодогч нь нягтлан бодогчоор 2-оос доошгүй жил ажилласан бие даан санхүүгийн тайлан гаргах чадвартай байх
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.6-д “мэргэжлийн нягтлан бодогч” гэж их, дээд сургууль, коллежийг нягтлан бодогчийн мэргэжлээр бакалавр буюу түүнээс дээш зэргээр төгссөн хүнийг" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бүртгэлээр тавих дотоод хяналтыг үр нөлөөтэй байхаар сайжруулах талаар аудитын зөвлөмж өгөв.

3. Харилцах дансанд буй 0.5 сая төгрөгийг мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр тайлагнаагүй байгаа нь Аудитын Оршин байх: "санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө, авлага, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байх" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл болон дансны өглөгийг тус бүр 0.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, аудитаар залруулав.

4. Жилийн эцсийн бараа материал 5.7 сая төгрөгийн үлдэгдэлд тооллого хийж, тооцоо бодоогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1-д заасны дагуу жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө бараа материалын үлдэгдэлд тооллого хийж, тооцоог боддог байх талаар зөвлөгөө өгөв.

5. Үндсэн хөрөнгөнд түүвэр тооллого хийхэд 1.2 сая төгрөгний анхны өртөгтэй Dell нөүтбүүк нь ажлын байранд оршин байхгүй /өмнөх нягтлан бодогчтой холбоотой, шүүхийн зарга маргаантай/ байна. Гэтэл 2015-2016 онуудад 0.6 сая төгрөгний элэгдэл байгуулсан нь Аудитын Оршин байх: "санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө, авлага, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байх" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант оны элэгдлийн зардлыг 0.3 сая төгрөгөөр бууруулан, өмнөх үеийн үр дүнг 0.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн аудитаар залруулав.

5.1 Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг "0" үлдэгдэлтэй болсон 212.8 сая төгрөгний анхны өртөгтэй, 58 ширхэг 54 төрлийн хөрөнгүүд, мөн зах зээлийн үнээс хэт доогуур өртөгтэй хөрөнгүүд байгаа нь Аудитын Үнэлгээ: Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг тайлант хугацаанд "Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимтай нийцүүлэн зөв үнээр бүртгэсэн байх" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: "0" үлдэгдэлтэй болон зах зээлийн үнэ цэнээс доогуур өртөгтэй үндсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийлгэх талаар аудитын зөвлөмж өгөв.

6. Тайлант оны санхүүгийн тайлангаар 0.2 сая төгрөгний өглөгтэй, 0.9 сая төгрөгний авлагатай гэж тайлагнасан боловч тайлант оны өглөгийг бүрэн тусгаагүй байна. Тухайлбал: Аудитын үйлчилгээний төлбөр 1.1 сая төгрөг, өмнөх жилийн томилолтын тооцооны үлдэгдэл 1.3 сая төгрөгийг тус тус өглөгөөр бүртгээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", мөн Ёкозуна ХХК-д 2017 оны 1-6 дугаар сарын интернетийн төлбөр болох 0.7 сая төгрөгийг урьдчилан шилжүүлээд, төлбөртэй авлага гэж буруу ангилан бүртгэсэн нь 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасныг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын үйлчилгээний төлбөр 1.1 сая төгрөгийг бараа, үйлчилгээний зардлын өглөгөөр, 0.7 сая төгрөгний урьдчилж төлсөн интернетийн төлбөрийг урьдчилж төлсөн зардал дансанд, 0.2 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тайлант үеийн үр дүн руу тус тус аудитаар залруулав.

7. Цалин хөлстэй холбоотой зөрчлүүд:

- 11 дүгээр сард Б/37 тоот захирамжаар ажилчдад 1-11 дүгээр сарын илүү цагийн цалин болох 10.2 сая төгрөгийг
- 12 дугаар сард Б/39 тоот захирамжаар үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээний биелэлтэнд 7.5 сая төгрөгийг бодож олгосон боловч үр дүнгийн нэмэгдлийг үндсэн цалингаас бус сарын цалингаас /бүх төрлийн нэмэгдэл цалинг оруулан/ бодож олгосон
- Тайлант оны 9 дүгээр сард захирагчийн Б/24 тоот захирамжаар 2 албан тушаалтанд ур чадварын нэмэгдлийг сар бүр 25 хувиар нийт 0.8 сая төгрөг /10-12 дугаар саруудад/ олгосон
- Ажилчдын ээлжийн амралтын тооцоололд хоол, унааны мөнгө болох шууд бус орлогыг оруулан дундаж цалинг буруу тооцсоноос ажилчдад 0.6 сая төгрөгийг илүү, 0.1 сая төгрөгийг дутуу олгосон
- Ажлаас чөлөөлөгдөж байгаа ажилчдад ажилласан хугацааны ээлжийн амралтын олговрыг бодож олгоогүй
- Ажилчдын цалингаас суутгасан НДШ, нийгмийн даатгалын тайлангийн даатгуулагчаас суутгасан НДШ-ээс 0.15 сая төгрөгөөр зөрүүтэй
- Шууд бус орлого болох хоолны мөнгөнөөс ХХОАТ-ыг буруу тооцож, суутгаснаас 0.2 сая төгрөгний ХХОАТ-ыг төсөвт төвлөрүүлэлгүй, ажилчдад илүү олгосон
- Сарын ажлын хоногийг буруу тооцсоноос хоолны мөнгийг 0.6 сая төгрөгөөр илүү олгосон байна.

Дээрх алдаа, зөрчлүүд нь:

- 1995 оны 96 дугаар тогтоолын 4-р хавсралтын 5-д "Ур чадварын нэмэгдлийг зөвхөн тухайн албан тушаал эрхэлж буй хугацаанд, жинхэнэ ажилласан цагт ноогдох албан тушаалын цалингаас тооцож сар тутам олгоно. Ажлын үр дүн буурсан нөхцөлд ур чадварын нэмэгдлийг олгохгүй.",
- Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралтын 15-д "Ажилтан ажлаас халагдах үед ажил олгогч нь түүнтэй

ээлжийн амралтын тооцоог заавал хийнэ.”, 2 дугаар хавсралтын 3-д “Ээлжийн амралтын олговрыг уг ажилтны ээлжийн амралт эдлэхээс өмнөх ажлын нэг жилийн хугацааны дундаж цалин хөлсийг үндэслэн тодорхойлно”,

- ХХОАТ-ын тухай хуулийн 17.1.2 "энэ хуулийн 11.1.2-11.1.5-д заасан орлогын тухайд нийлбэр дүнгээр нь татвар ногдуулна гэж заасантай зөрчилдөж байна. Мөн ажилчдын үр дүн, ур чадварыг үнэн зөв дүгнээгүй, төсвийг зохистой удирдаж, үр дүнтэй зарцуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: ХХОАТ-ын өглөгийн зөрүү 0.2 сая төгрөгийг ХХОАТ-ын өглөг, ажиллагсдаас авах авлагыг нэмэгдүүлэн аудитаар залруулав.

Хууль, тогтоомж зөрчиж илүү олгосон 14.7 сая төгрөгийн нэмэгдэл цалинд албан шаардлага хүргүүлэв.

8. Тус чөлөөт бүс нь харилцаа холбооны Мобиком ХХК, Юнител ХХК, Жи-Мобайл ХХК, Скайтел ХХК -дад төрийн өмчийг түрээслүүлж, түрээсийн орлогод 12.1 сая төгрөг хүлээн авсан ба ТӨХ-д 2.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 2.45 сая төгрөгийг төвлөрүүлсэн /12 дугаар сард/ бөгөөд дутуу шилжүүлсэн 56.0 мянган төгрөгийг өглөгөөр тусгаагүй байгаа нь ТӨХ-ны 2009 оны 11 дүгээр сарын 24-ний 408 тоот тушаалын 3.12 “Илүүдэлтэй байгаа хөрөнгийг бусдад түрээслүүлсэн тохиолдолд ТӨХ-ны зөвшөөрлийг үндэслэн шийдвэрлэх бөгөөд талбайн түрээсийн орлогын 20 хувийг ТӨХ-ны төрийн санд сар бүр төвлөрүүлнэ” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТӨХ-нд дутуу шилжүүлсэн 56.0 мянган төгрөгийг өглөгөөр бүртгэж, аудитаар залруулав.

Түрээсийн орлогыг харилцагч байгууллагуудаас сар бүр бүрэн цуглуулж, түрээсийн орлогын 20 хувийг улсын төсөвт сар бүр төвлөрүүлдэг байх талаар зөвлөгөө өгөв.

9. Шатахууны картны үлдэгдэлд бодогдсон 96.4 мянган төгрөгний урамшууллыг бусад орлогоор, 12 дугаар сарын 31-ний 62.7 мянган төгрөгний үлдэгдлийг урьдчилж төлсөн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй, жолоочийн тооцооны хуудас болон анхан шатны баримтууд үдэгдээгүй, шатахууны картанд шилжүүлж байгаа төлбөрийг тухай бүр урьдчилж төлсөн зардал дансаар хуримтлуулан бүртгэлгүйгээр төлбөр төлөгдсөн үед нь шууд зардлаар хүлээн зөвшөөрсөн нь Төсвийн тухай хуулийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.” 26.2-д “Төсвийн бүртгэлийг тохируулсан аккрузл сууриар бүртгэж, тайлагнана.” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шатахууны картны үлдэгдэл 62.7 мянган төгрөг болон үлдэгдэлд бодогдсон 96.4 мянган төгрөгийн урамшууллыг аудитаар залруулав.

10. Тайлант онд үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй чөлөөт бүсийн хашаанд 1.7 сая төгрөгний урсгал засвар хийсэн байна. Засварын материалын зардал болох 1.2 сая төгрөгөөр тухайн хөрөнгийн өртгийг нэмэгдүүлэлгүй тайлант онд зардлаар хүлээн зөвшөөрсөн байгаа нь Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны “Төсөвт байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын 4.34-д "Үндсэн хөрөнгийн засварын зардал нь үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг уртасгах гэх мэт уг хөрөнгөөс хүртэх өгөөжийг нэмэгдүүлж байвал уг зардлыг капиталжуулан үндсэн хөрөнгийн анхны өртгийг нэмэгдүүлнэ. Бусад тохиолдолд тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын дагуу урсгал засварын зардлыг бүртгэх талаар зөвлөгөө өгч, 1.2 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийг капиталжуулан аудитаар залруулав.

11. Тайлант оны гүйцэтгэлээр 4.9 сая төгрөгний томилолтын зардал гарсан боловч 1.3 сая төгрөг нь 2015 оны томилолтын тооцооны үлдэгдэл төлбөр байна.

Томилолтоор ажилласан хоногийг тооцохдоо ирсэн, явсан зам хоногийг нэг өдөрт тооцож хасалт хийлгүй томилолтын зардлыг илүү олгодог, зам хоногийн мөнгө болох 1.1 сая төгрөг нь анхан шатны баримтгүй байна.

Томилолтын зардлыг олгохдоо дараа тооцоогоор дамжуулалгүй, мөнгө олгох бүртгээ шууд зардлаар хүлээн зөвшөөрдөг байна.

Эдгээр нь Аудитын Иж бүрэн байх: "аж ахуйн нэгж, байгууллага тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээ, үлдэгдэл буюу үйл явдал, нөхцөл байдлуудаас бүртгээгүй, нэмж тодруулаагүй, орхигдуулсан зүйлсгүй байх" гэсэн батламж мэдэгдэл

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх, томилолтыг дараа тооцоогоор дамжуулан бүртгэх талаар аудитын зөвлөмж өгөв.

12. Тус чөлөөт бүс нь сар бүр төлдөг тогтмол зардлууд болох ашиглалтын зардал, цахилгааны зардал, утасны зардал, хэвлэлийн зардал, түрээсийн зардал зэрэг зардлуудаа аккрузл сууриар бүртгээгүй, өмнөх жилд өгч байсан зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.", 26.2-д "Төсвийн бүртгэлийг тохируулсан аккрузл сууриар бүртгэж, тайлагнана." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 26.1 "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө." гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах талаар аудитын зөвлөмж өгөв.

Материаллаг бүс дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Бараа материал болон үндсэн хөрөнгийг байршил тус бүрээр эд хариуцагчид хариуцуулан /Улаанбаатар хот, Баян-Өлгий аймаг г.м/, зориулалтаар нь үнэн зөв ангилан бүртгэдэггүй байна.

1.1 Бараа материалын ангилалд орох 0.6 сая төгрөгний 7 төрлийн 7 ш хөрөнгийг үндсэн хөрөнгөнд, үндсэн хөрөнгийн ангилалд орох 0.2 сая төгрөгний өртөгтэй интернетийн төхөөрөмжийг тайлант үеийн зардлаар бүртгэн тайлагнажээ.

1.2 Мөн 35.4 сая төгрөгний өртөгтэй 7.9 сая төгрөгний хуримтлагдсан элэгдэлтэй компьютер түүний дагалдах хэрэгслийг машин, тоног төхөөрөмж ангилалд оруулан бүртгэсэн байгаа нь Аудитын *Толилуулга ба тодруулга*: "Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг зөв ангилж, тодруулж, тайлагнасан байх гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материал болон үндсэн хөрөнгөнд Аудитын *Толилуулга ба тодруулга*: "Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг зөв ангилж, тодруулж,

тайлагнасан байх” гэсэн батламж мэдэгдлийг хэрэгжүүлэн ажиллах талаар зөвлөгөө өгч ангилал буруу хийгдсэн 0.8 сая төгрөгийн хөрөнгүүдийг аудитаар залруулав.

2. Тайлант онд үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, элэгдэл байгуулах аргыг өөрийн байгууллагын онцлогт тохируулан шинээр тогтоож, мөрдөн ажиллаагүй, өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Энэ нь УСНББОУС 17-той нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шинээр боловсруулах нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтээ үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулах арга, ашиглах хугацааг Өмч хамгаалах комиссын шийдвэрээр өөрийн байгууллагын онцлогт тохируулан сонгож, нягтлан бодох бүртгэлдээ мөрдлөг болгон ажиллах талаар зөвлөгөө өгөв.

3. Гэрээт ажилчдын нийгмийн даатгалын шимтгэлийг тооцохдоо даатгуулагчийн төрлийн кодыг энгийн ажилтнаар сонгож тайлагнажээ. Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлд нэмэгдэл цалин урамшуулал болох зэргийн нэмэгдэл, төрийн албанд ажилласны нэмэгдэл, илүү цагийн цалин г.м нэмэгдлүүдийг төрөл тус бүрээр харуулдаггүй, нийт дүнгээр тайлагнасан байна. Цалин хөлсний тооцоололд өмнөх жилд гарч байсан алдаа, зөрчлүүд дахин давтагдаж байна.

Шийдвэрлэсэн нь: Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийг тусад нь архивладаг байх талаар зөвлөгөө өгөв.

4. Захирагчаас гарсан зарим захирамжууд дутуу, Б/39 болон Б/24 тоот захирамжууд нь хууль тогтоомжтой нийцээгүй, зохих шийдвэрийн үндэслэлгүй байна. Тухайлбал Б/39 тоот захирамжинд: “2016 оны үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээний биелэлтийг бүтэн жилийн байдлаар дүгнэн хэлэлцээд гэрээний үүргээ хангалттай биелүүлсэн албан хаагч, ажилчдад нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгосугай” гэсэн захирамж нь Чөлөөт бүсийн тухай хуулийн 8.6-д “Чөлөөт бүсийн захирагч эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргах бөгөөд уг захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол өөрөө, эсхүл чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн өөрчлөх буюу хүчингүй болгоно.” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Чөлөөт бүсийн тухай хуулийн 8.6-г хэрэгжүүлэн ажиллах талаар зөвлөгөө өгөв.

5. Чөлөөт бүсийн захирагчийн 2015 оны 05 дугаар сарын 16 тоот захирамжаар батлагдан мөрдөгдөж байгаа Хөдөлмөрийн дотоод журмын 4.1.10 “Төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээг байгуулах заавар болон төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэжлийн түвшин (үр дүнгийн гэрээний биелэлт)-ийг үнэлэх журам батлах тухай. 2007.02.13-ны өдрийн Төрийн албаны зөвлөлийн 48 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах” гэсэн заалт нь 2012 оны 134 тоот тогтоолоор хүчингүй болсон байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод журмыг шинэчлэн сайжруулж, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журманд нийцүүлдэг байх талаар аудитын зөвлөмж өгөв.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад томилолтын зардалтай холбоотой 2.4 сая төгрөг, цалин хөлсний тооцоололтой холбоотой 5.1 сая төгрөгийн алдааг залруулах боломжгүй байгаа тул зөвлөмж бэлтгэн хүргүүлээ.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“Цагааннуур” чөлөөт бүсийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Цаашид аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан ажиллах.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Цагааннуур” чөлөөт бүсийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 27.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 5.4 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан ба 14.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 7.5 сая төгрөгийн алдаанд зөвлөмж хүргүүлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

“Цагааннуур” чөлөөт бүсийн 2015 оны санхүүгийн тайланд Голден пэйж Аудит ХХК-аас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Бид “Цагааннуур” чөлөөт бүсийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлтийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайлан нь УСНББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна гэж үзлээ.

Аудит хийсэн санхүүгийн тайлан 8 хуудас, хавсралтууд тус тус хавсаргав.

2017 оны 2 дугаар сар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Цагааннуур” чөлөөт бүсийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Цагааннуур” чөлөөт бүсийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Ажиглалт

1. Томилолтын зардлыг олгохдоо дараа тооцоогоор дамжуулалгүй, мөнгө олгох бүртгээ шууд зардлаар хүлээн зөвшөөрдөг байна. Тухайлбал: Тайлант оны гүйцэтгэлээр 4.9 сая төгрөгний томилолтын зардал гарсан боловч 1.3 сая төгрөг нь 2015 оны томилолтын тооцооны үлдэгдэл ба өмнөх жилийн санхүүгийн тайлангаар өглөгөөр тайлагнаагүй байна.

2. Томилолтоор ажилласан хоногийг тооцохдоо ирсэн, явсан зам хоногийг нэг өдөрт тооцож хасалт хийлгүй томилолтын зардлыг илүү олгодог.

3. Зам хоногийн мөнгө болох 1.1 сая төгрөг нь анхан шатны хүчин төгөлдөр баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь: Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх",

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;" гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн зарчим, стандартыг баримтлан ажиллаагүйгээс бүртгэлийн явцад санаатай болон санамсаргүй алдаанууд гарч, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, НББ-ийн хууль, УСНББОУС зөрчигдөх, удирдлага болон мэдээлэл хэрэглэгчдийг буруу мэдээллээр хангах, улмаар байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ноцтой зөрчил үүсч болох төдийгүй нөхөн татвар, татварын алданги торгууль хүлээх эрсдэл бий болно.

Зөвлөмж

1. Томилолтын зардлыг дараа тооцоогоор дамжуулан, томилолтоор ажиллаад ирсний дараа ажлын 5 хоногийг дотор тооцоог хийдэг байх

2. Томилолтоор ажилласан хоногийг тооцохдоо ирсэн, явсан зам хоногийг нэг өдөрт тооцох

3. Анхан шатны баримтыг тухай бүр бүрдүүлдэг байх

Төсвийн захирагчийн хариу

1. Зам хоногийн мөнгө болох 1.1 сая төгрөгийн анхан шатны баримтыг нөхөн бүрдүүлж, цаашдаа холбогдох хууль журмын дагуу ажил гүйлгээг бүртгэж, хэрэгжүүлэн ажиллах болно.

Ажиглалт

Тус чөлөөт бүс нь сар бүр төлдөг тогтмол зардлууд болох ашиглалтын зардал, цахилгааны зардал, утасны зардал, хэвлэлийн зардал, түрээсийн зардал зэрэг зардлуудаа аккруэл сууриар бүртгээгүй, өмнөх жилд өгч байсан зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.”, 26.2-д “Төсвийн бүртгэлийг тохируулсан аккруэл сууриар бүртгэж, тайлагнана.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлд аккруэл суурийг мөрдлөг болгох

Эрсдэлүүд

Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль зөрчигдөх, удирдлага болон мэдээлэл хэрэглэгчдийг буруу мэдээллээр хангах, улмаар байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ноцтой зөрчил үүсч болох төдийгүй нөхөн татвар, татварын алданги торгууль хүлээх эрсдэл бий болно.

Төсвийн захирагчийн хариу

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүртгэлээ аккруэл сууриар хөтлөн ажиллах болно.

Ажиглалт

Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг "0" үлдэгдэлтэй болсон 212.8 сая төгрөгний анхны өртөгтэй, 58 ширхэг 54 төрлийн хөрөнгүүд, мөн зах зээлийн үнээс хэт доогуур өртөгтэй хөрөнгүүд байна.

Энэ нь УСНББОУС 17-ийн “Хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилт”-ийн 49-д үндсэн хөрөнгөнд 3-5 жил тутам дахин үнэлгээ хийх нь тохиромжтой,

Аудитын Үнэлгээ: Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг тайлант хугацаанд "Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимтай нийцүүлэн зөв үнээр бүртгэсэн байх” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Үндсэн хөрөнгийн бүртгэл эмх цэгцгүй, хөдөлгөөн өөрчлөлтөд бүртгэлээр тавих хяналт сул, хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгээгүйгээс хөрөнгө үнэгүйдэх, бүртгэлийн стандарт зөрчигдөх, үндсэн хөрөнгө алдагдах, бүрэн бүтэн байдлаа алдах, ашиглагдахгүй үндсэн хөрөнгө бий болох, хөрөнгө эзгүйдэх, улмаар үр дүн буруу илэрхийлэгдэж мэдээлэл хэрэглэгчдийг худал мэдээллээр хангах эрсдэлтэй.

Зөвлөмж

Ашиглалтын шаардлага хангаж байгаа “0” үлдэгдэлтэй хөрөнгүүдийг болон зах зээлийн үнээс хэт доогуур өртөгтэй хөрөнгүүдийг УСНББОУС 17-н дагуу бодит үнэ цэнээр үнэлэх

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрч байна. Цаашдаа зөвлөмжийн дагуу холбогдох хууль, журмыг хэрэгжүүлэн ажиллах болно.

Ажиглалт

1. Тайлант онд дотоод хяналтын ажилтан /мэргэжлийн бус/ байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан гэх боловч, байгууллагад бүртгэлээр тавих хяналт сул, мэргэжлийн ур чадвар дутмаг, ажлын үр дүн чанар муутай, нягтлан бодогчийн хийж гүйцэтгэсэн ажилд хяналт хангалтгүй тавьдаг байна.

2. Тайлант онд харилцагч байгууллагуудтай байгуулсан гэрээнүүдэд жагсаалт /товъёог/ үйлдэн хэрэгжсэн, хэрэгжээгүй гэрээнүүдийг дүгнээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхи йэтгээд тодорхойлно”, Төсвийн тухай хуулийн 16.5.6-д "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Дотоод хяналт үр нөлөөгүй байснаар байгууллагын хөрөнгө шамшигдах, тайлан тооцоо буруу илэрхийлэгдэх, мэдээлэл хэрэглэгчдийг буруу мэдээллээр хангах эрсдэлтэй.

Зөвлөмж

1. Бүртгэлээр тавих хяналтыг үр нөлөөтэй байхаар зохион байгуулах

2. Тайлант онд байгуулсан гэрээнүүдэд жагсаалт үйлдэн, хэрэгжсэн хэрэгжээгүй гэрээнүүдийг тухай бүр дүгнэдэг байх

Төсвийн захирагчийн хариу

1. Төсвийн тухай хуулийн 16.5.6-д заасны дагуу дотоод хяналтын ажилтанг холбогдох хууль, тогтоомж болон засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын 4.4-д заасны шаардлагад нийцүүлэн шинээр томилж, байгууллагын үйл ажиллагаанд тавигдах хяналтыг сайжруулна.

2. Харилцагч байгууллагуудтай байгуулсан гэрээнүүдэд жагсаалт/ товъёог/ үйлдэн, жилийн эцэст тооцоо нийлж дүгнэн, журмын дагуу үдэж, архивт шилжүүлнэ.

Ажиглалт

Нягтлан бодогч нь ажлын байрны тодорхойлолтонд заасан ажил үүргийг үнэн зөв чанартай сайн хийж гүйцэтгээгүй, нягтлан бодогчийн ажлын байрны тодорхойлолтонд хүчингүй болсон хууль тогтоомжийг ашигласан ба мэргэжлийн мэдлэг дутмаг байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.6-д “мэргэжлийн нягтлан бодогч” гэж их, дээд сургууль, коллежийг нягтлан бодогчийн мэргэжлээр бакалавр буюу түүнээс дээш зэргээр төгссөн хүнийг”,

Сангийн сайдын 2012 оны 294 тоот төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журмын 2.1.5-д Шууд захирагч нарын ахлах нягтлан бодогч нь нягтлан бодогчоор 2-оос доошгүй жил ажилласан бие даан санхүүгийн тайлан гаргах чадвартай байх гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодогч мэргэжлийн мэдлэг чадвар дутуу байснаар бүртгэлийн явцад санаатай болон санамсаргүй алдаанууд гарч, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, НББ-ийн хууль, УСНББОУС зөрчигдөх, удирдлага болон мэдээлэл хэрэглэгчдийг буруу мэдээллээр хангах, улмаар байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ноцтой зөрчил үүсч болох төдийгүй нөхөн татвар, татварын алданги, торгууль хүлээх эрсдэл бий болно.

Зөвлөмж

1. Нягтлан бодогчийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх
2. Нягтлан бодогчийн ажил үүргийг ажлын байрны тодорхойлолтонд заасны дагуу үнэн зөв чанартай гүйцэтгэхэд нь хяналт тавьж ажиллуулах

Төсвийн захирагчийн хариу

1. Нягтлан бодогчийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн, одоо хүчин төгөлдөр байгаа хууль тогтоомжийг оруулан шинээр боловсруулан баталгаажуулж, нягтлан бодогчийн ажил үүргийг ажлын байрны тодорхойлолтонд заасны дагуу үнэн зөв чанартай гүйцэтгэхэд нь хяналт тавьж ажиллуулна.

"ЦАГААННУУР" ЧӨЛӨӨТ БҮС
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
(ТӨГРӨГӨӨР)

Балансын зүйл	2015.12.31	2016.12.31	Залруулга	Аудитлагдсан тайлан
1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ				
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ				
Жижиг мөнгөн сан	200,000.00	200,000.00	472,900.00	672,900.00
Банкинд байгаа бэлэн мөнгө	200,000.00	200,000.00		200,000.00
	0.00	0.00	472,900.00	472,900.00
АВЛАГА	4,309,037.16	859,594.22	-552,122.28	307,471.94
Төлбөрт үйлчилгээний авлага		729,000.00	-729,000.00	0.00
Ажилчин албан хаагчдаас авах авлага			183,168.84	183,168.84
Бусад авлага	4,309,037.16	130,594.22	-6,291.12	124,303.10
УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	3,929,532.29	3,929,532.29	791,693.82	4,721,226.11
Урьдчилгаа тооцоо	3,929,532.29	3,929,532.29		3,929,532.29
Урьдчилж төлсөн зардал			791,693.82	791,693.82
БАРАА МАТЕРИАЛ	5,904,118.00	5,784,858.00	670,650.00	6,455,508.00
Түүхий эд материал	819,900.00	0.00		0.00
Хангамжийн материал	4,617,469.00	4,617,469.00	670,650.00	5,288,119.00
Хүнсний материал				0.00
Бичиг хэргийн материал	466,749.00	1,167,389.00		1,167,389.00
Бусад				0.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,342,687.45	10,773,984.51	1,383,121.54	12,157,106.05
2. ЭРГЭЛТИЙН БҮС ХӨРӨНГӨ				
ҮНДСЭН ХӨРӨНГӨ				
<u>Биет хөрөнгө</u>	982,825,234.90	958,296,422.24	1,473,780.04	959,770,202.28
Барилга, байгууламж	1,204,660,941.00	1,204,660,941.00	1,250,000.00	1,205,910,941.00
Хуримтлагдсан элэгдэл	-264,452,887.45	-311,378,618.29		-311,378,618.29
Авто тээврийн хэрэгсэл	38,000,000.00	38,000,000.00		38,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-28,124,413.53	-31,957,746.81		-31,957,746.81
Машин тоног төхөөрөмж	57,032,979.00	89,137,679.00	-295,000.00	88,842,679.00
Хуримтлагдсан элэгдэл	-25,932,476.93	-35,857,065.52	627,572.90	-35,229,492.62
Тавилга, аж ахуйн эд хогшил	15,564,095.82	20,735,645.82	-137,350.00	20,598,295.82
Хуримтлагдсан элэгдэл	-13,965,003.01	-15,086,412.96	28,557.14	-15,057,855.82
Номын фонд	42,000.00	42,000.00		42,000.00
<u>Биет бүс хөрөнгө</u>	33,599,999.86	231,249.89	0.00	231,249.89
Программ хангамж	950,000.00	1,200,000.00		1,200,000.00
Хорогдуулга	-950,000.10	-968,750.07		-968,750.07
Бусад	187,000,000.00	187,000,000.00		187,000,000.00
Хорогдуулга	-153,400,000.04	-187,000,000.04		-187,000,000.04
ЭРГЭЛТИЙН БҮС ХӨРӨНГИЙН ДҮН	1,016,425,234.76	958,527,672.13	1,473,780.04	960,001,452.17
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,030,767,922.21	969,301,656.64	2,856,901.58	972,158,558.22
3. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР				
Ажилчидтай холбогдсон өглөг		149,070.75	-149,070.75	0.00
Бараа үйлчилгээний зардлын өглөг			1,628,900.00	1,628,900.00
Бусад өглөг	10,596,000.00	31,737.28	176,877.72	208,615.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	10,596,000.00	180,808.03	1,656,706.97	1,837,515.00
4. УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР				0.00
Урт хугацаат зээл				0.00

Балансын зүйл	2015.12.31	2016.12.31	Залруулга	Аудитлагдсан тайлан
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0.00	0.00	0.00	0.00
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	10,596,000.00	180,808.03	1,656,706.97	1,837,515.00
5. ЭЗНИЙ ӨМЧ				
Засгийн газрын оруулсан капитал	70,863,483.00	70,863,483.00		70,863,483.00
Смнхх үеийн үр дүн	948,421,526.62	948,421,526.62	443,065.63	948,864,592.25
Тайлант үеийн үр дүн	0.00	-51,051,073.60	757,128.98	-50,293,944.62
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	886,912.59	886,912.59		886,912.59
ЦЭВЭР ХӨРСӨНГӨ/СМЧИЙН ДҮН	1,020,171,922.21	969,120,848.61	1,200,194.61	970,321,043.22
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРСӨНГӨ/СМЧИЙН ДҮН	1,030,767,922.21	969,301,656.64	2,856,901.58	972,158,558.22

0.00

"ЦАГААННУУР" ЧӨЛӨӨТ БҮС
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
(ТӨГРӨГӨӨР)

Үзүүлэлт	2015.12.31	2016.12.31	Залруулга	Аудитлагдсан тайлан
1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО				
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	198,460,680.00	279,147,700.00	0.00	279,147,700.00
Улсын төсвөөс	0.00	0.00	279,147,700.00	279,147,700.00
Урсгал				0.00
Хөрөнгийн				0.00
Орон нутгийн төсвөөс				0.00
Бусад төсөвт байгууллагаас	198,460,680.00	279,147,700.00	-279,147,700.00	0.00
Нийгмийн даатгалын сангаас				0.00
Бусад тусгай зориулалтын сангаас	0.00	0.00		0.00
Тусламжийн орлого				0.00
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	19,722,253.11	63,207,681.35	40,406.82	63,248,088.17
Өмчийн орлого	7,568,000.00	63,201,800.00	-56,000.00	63,145,800.00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого		5,881.35		5,881.35
Үнэ төлбөргүй хөрөнгийн орлого	12,154,253.11		96,406.82	96,406.82
Торгууль, төлбөрийн орлого				0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	218,182,933.11	342,355,381.35	40,406.82	342,395,788.17
2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ				
АЖИЛЛАГЧИДАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	121,758,128.71	193,249,300.25	0.00	193,249,300.25
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	109,807,277.20	174,240,852.31	0.00	174,240,852.31
Цалин	109,807,277.20	174,240,852.31		174,240,852.31
Цалингийн тусгай нэмэгдлүүд /Хоол унаа/				0.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	11,950,851.51	19,008,447.94	0.00	19,008,447.94
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	9,975,108.10	15,668,226.58		15,668,226.58
Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,975,743.41	3,340,221.36		3,340,221.36
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ				
Бараа, үйлчилгээний урсгал зардал	137,222,620.17	200,157,154.70	-716,722.16	199,440,432.54
Тогтмол зардал	7,098,987.00	5,896,000.00	0.00	5,896,000.00
Гэрэл цахилгааны зардал	1,789,787.00	1,238,000.00		1,238,000.00
Түлш, халаалтын зардал	4,846,200.00	4,158,000.00		4,158,000.00
Цэвэр, бохир усны зардал	463,000.00	500,000.00		500,000.00
Үйл ажиллагааны зардал	0.00	0.00	0.00	0.00
Хоол				
Эм				
Бусад бараа үйлчилгээний зардал	130,123,633.17	194,261,154.70	-716,722.16	193,544,432.54
Бичиг хэргийн материал	434,300.00	1,480,100.00		1,480,100.00
Тээвэр, шатахууны зардал	1,215,400.00	4,801,900.00	33,713.00	4,835,613.00
Шуудан холбооны зардал	1,107,097.90	3,964,419.05	-238,300.00	3,726,119.05
Дотоод томилолтын зардал	4,589,250.00	4,911,900.00		4,911,900.00
Гадаад томилолтын зардал				0.00
Ном, хэвлэлийн зардал	12,500.00			0.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал				0.00
Сургалт семинарын зардал				0.00
Эрдэм шинжилгээний ажлын зардал				0.00
Жижиг эд хогшил худалдан авах зардал				0.00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах				0.00
Төлбөр хураамж, жижиг татварууд	198,200.00	198,200.00		198,200.00
Мэдээлэл технологийн үйлчилгээ	350,000.00	1,100,000.00		1,100,000.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	16,500.00	27,500.00		27,500.00
Даатгалын үйлчилгээ	200,000.00	352,100.00		352,100.00
Харуул хамгаалалтын зардал				0.00
Банкны үйлчилгээний хураамж				0.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлч төлбөр				0.00
Маягт хэвлүүлэх зардал				0.00
Урсгал засварын зардал	1,600,000.00	1,792,281.35	-1,250,000.00	542,281.35
Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал				0.00
Гадаадын зочны зардал				0.00
Бусад зардал				0.00
Байрны түрээсийн зардал	5,625,570.00	4,800,000.00		4,800,000.00

Үзүүлэлт	2015.12.31	2016.12.31	Залруулга	Аудитлагдсан тайлан
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	1,534,750.00	2,779,500.00		2,779,500.00
Аудит	300,000.00	1,000,000.00	1,100,000.00	2,100,000.00
Холбооны суваг ашигласны зардал				0.00
Элэгдлийн зардал	90,919,803.37	95,423,812.63	-362,135.16	95,061,677.47
Хөтөлбөр арга хэмжээний зардал				0.00
Төвлөрүүлэх шилжүүлэг		70,774,441.67		70,774,441.67
Гарсан зардлаа дансны нэгдсэн жагсаалтаас авах				0.00
Олон улсын байгууллагын гишүүний татвар				0.00
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	675,000.00	855,000.00		855,000.00
Ногоон байгууламжийн хөрөнгө оруулалт	21,345,261.90			0.00
Капиталжаагүй хөрөнгө оруулалтын зардал				0.00
Гарсан зардлаа дансны нэгдсэн жагсаалтаас авах				0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	258,980,748.88	393,406,454.95	-716,722.16	392,689,732.79
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-40,797,815.77	-51,051,073.60	757,128.98	-50,293,944.62
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО				0.00
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз /бодит/				0.00
Үндсэн хөрөнгө худалдсаны олз				0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00	0.00	0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ				0.00
Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз /бодит/				0.00
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,887,130.23			0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,887,130.23	0.00	0.00	0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-43,684,946.00	-51,051,073.60	757,128.98	-50,293,944.62

"ЦАГААННУУР" ЧӨЛӨӨТ БҮС
АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
(ТӨГРӨГӨӨР)

Үзүүлэлт	2015.12.31	2016.12.31
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	198,460,680.00	279,147,700.00
Улсын төсвөөс	198,460,680.00	0.00
Урсгал		
Хөрөнгийн		
Орон нутгийн төсвөөс		
Бусад төсөвт байгууллагаас		
Нийгмийн даатгалын сангаас		
Бусад тусгай зориулалтын сангаас		
Тусламжийн орлого		
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	4,904,000.00	65,865,800.00
Өмчийн орлого		
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	4,904,000.00	65,865,800.00
Үнэ төлбөргүй хөрөнгийн орлого		
Торгууль, төлбөрийн орлого		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	203,364,680.00	345,013,500.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	121,865,623.20	192,290,049.28
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	109,807,277.20	174,119,349.28
Цалин	106,357,277.20	174,119,349.28
Цалингийн тусгай нэмэгдлүүд	3,450,000.00	0.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	12,058,346.00	18,170,700.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	12,058,346.00	18,170,700.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж		
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ		
Бараа, үйлчилгээний урсгал зардал	85,999,216.80	113,906,650.72
Тогтмол зардал	7,098,987.00	5,896,000.00
Гэрэл цахилгааны зардал	1,789,787.00	1,238,000.00
Түлш, халаалтын зардал	4,846,200.00	4,158,000.00
Цэвэр, бохир усны зардал	463,000.00	500,000.00
Үйл ажиллагааны зардал	0.00	0.00
Хоол		
Эм		
Бусад бараа үйлчилгээний зардал	78,900,229.80	108,010,650.72
Бичиг хэргийн материал	190,700.00	1,360,840.00
Тээвэр, шатахууны зардал	1,215,400.00	4,801,900.00
Шуудан холбооны зардал	1,107,097.90	4,693,419.05
Дотоод томилолтын зардал	4,589,250.00	4,911,900.00
Гадаад томилолтын зардал		0.00
Ном, хэвлэлийн зардал	12,500.00	0.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал		
Сургалт семинарын зардал		

Үзүүлэлт	2015.12.31	2016.12.31
Эрдэм шинжилгээний ажлын зардал		
Жижиг эд хогшил худалдан авах зардал		
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах		
Төлбөр хураамж, жижиг татварууд	198,200.00	198,200.00
Мэдээлэл технологийн үйлчилгээ	350,000.00	1,100,000.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	16,500.00	27,500.00
Даатгалын үйлчилгээ	200,000.00	352,100.00
Харуул хамгаалалтын зардал		
Банкны үйлчилгээний хураамж		
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлч төлбөр	41,474,750.00	2,779,500.00
Маягт хэвлүүлэх зардал		
Багаж, техник хэрэгсэл		432,350.00
Урсгал засварын зардал	1,600,000.00	9,923,500.00
Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал		
Гадаадын зочны зардал		
Бусад зардал	300,000.00	1,000,000.00
Байрны түрээсийн зардал	5,625,570.00	4,800,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ		
Холбооны суваг ашигласны зардал		
Гарсан зардлаа дансны нэгдсэн жагсаалтаас авах		
Төвлөрүүлэн шилжүүлэх	16,845,101.90	70,774,441.67
Монгол улсыг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх		
Хөрөнгө оруулалт барьцаат техник	4,500,160.00	
Олон улсын байгууллагын гишүүний татвар		
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	675,000.00	855,000.00
Бусад		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	207,864,840.00	306,196,700.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-4,500,160.00	38,816,800.00
Хөрөнгийн орлого		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Бусад хөрөнгө борлуулсны орлого		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	0.00	38,343,900.00
Хөрөнгийн бусад зардал		
Гарсан зардлаа дансны нэгдсэн жагсаалтаас авах		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	0.00	38,343,900.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-38,343,900.00
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
Авсан зээл		
Төлсөн зээл		
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-4,500,160.00	472,900.00

Үзүүлэлт	2015.12.31	2016.12.31
Мөнгөтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,700,160.00	200,000.00
Мөнгөтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	200,000.00	672,900.00

"ЦАГААННУУР" ЧӨЛӨӨТ БҮС
АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
(ТӨГРӨГӨӨР)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2014 оны 12 дугаар сарын 31-ээрх үлдэгдэл	70,863,483.00	1,430,199.34	991,563,186.65		1,063,856,868.99
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-543286.75	543,286.75		0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	70,863,483.00	886,912.59	992,106,473.40	0.00	1,063,856,868.99
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Тайлант үеийн үр дүн			(86,173,669.78)		-86,173,669.78
Аудитын залруулга			42,488,723.00		42,488,723.00
Залруулга					0.00
2015 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	70,863,483.00	886,912.59	948,421,526.62	0.00	1,020,171,922.21
Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт			443,065.63		443,065.63
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	70,863,483.00	886,912.59	948,864,592.25	0.00	1,020,614,987.84
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Тайлант үеийн үр дүн			-51,051,073.60		-51,051,073.60
Залруулга			757,128.98		757,128.98
2016 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	70,863,483.00	886,912.59	898,570,647.63	-	970,321,043.22

"ЦАГААННУУР" ЧӨЛӨӨТ БҮС
АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
(ТӨГРӨГӨӨР)

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	280,649,700.00	274,239,058.33	6,410,641.67	97.72
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	280,649,700.00	274,239,058.33	6,410,641.67	97.72
III. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	280,649,700.00	274,239,058.33	6,410,641.67	97.72
Бараа үйлчилгээний зардал	280,649,700.00	274,239,058.33	6,410,641.67	97.72
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	178,111,400.00	174,119,349.28	3,992,050.72	97.76
Үндсэн цалин	165,188,600.00	161,136,749.28	4,051,850.72	97.55
Унаа хоолны хөнгөлөлт цалин	12,922,800.00	12,982,600.00	(59,800.00)	100.46
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,170,700.00	18,170,700.00	-	100.00
Бараа, үйлчилгээний бусад зардал	84,367,600.00	81,949,009.05	2,418,590.95	97.13
Гэрэл цахилгаан	1,238,100.00	1,238,000.00	100.00	99.99
Түлш халаалт	4,162,700.00	4,158,000.00	4,700.00	99.89
Цэвэр, бохир ус	500,000.00	500,000.00	-	100.00
Байрны түрээсийн зардал	4,800,000.00	4,800,000.00	-	100.00
Бичиг хэрэг	1,365,300.00	1,360,840.00	4,460.00	99.67
Тээвэр (шатахуун)	4,801,900.00	4,801,900.00	-	100.00
Шуудан, холбоо	4,693,800.00	4,693,419.05	380.95	99.99
Жижиг эд хогшил худалдан авах зардал	37,276,200.00	37,276,250.00	(50.00)	100.00
Урсгал засварын зардал	12,434,700.00	11,646,400.00	788,300.00	93.66
Дотоод албан томилолт	4,911,900.00	4,911,900.00	-	100.00
Мэдээллийн технологийн үйлчилгээ	1,350,000.00	1,350,000.00	-	100.00
Төр.өмнөөс гүйцэтгүүлсэн ажил.үйлч.төлбөр	2,779,500.00	2,779,500.00	-	100.00
Аудитын үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
Даатгалын үйлчилгээ	352,100.00	352,100.00	-	100.00
Тээврийн хэрэгслийн татвар	302,900.00	198,200.00	104,700.00	65.43
Тээврийн хэрэгслийн оношлогоо	38,500.00	27,500.00	11,000.00	71.43
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	2,360,000.00	855,000.00	1,505,000.00	36.23
IV. ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	345,013,500.00	(345,013,500.00)	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэх		65,865,800.00	(65,865,800.00)	
Төсвөөс санхүүжүүлэх		279,147,700.00	(279,147,700.00)	
Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл		200,000.00		
Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл		200,000.00	(200,000.00)	
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт		70,774,441.67	(70,774,441.67)	
Байгууллагын тоо	1.00	1.00	-	
Ажиллагсад бүгд	18.00	23.00	(5.00)	